



Нөөцийн загварчлал, тооцоо

Туршлага, иновацийг хослуулан илүү ихийг бүтээнэ

Арга барил

Манай геологичид хайгуулын ажил, мэдээллийн сангийн менежмент, нөөцийн тооцоо, түвшний хяналт, орчин нөхцөлийн загварчлалд ихээхэн туршлагажсан. Бид таны төслийг анхан шатны хайгуулын ажлаас эхлээд техник эдийн засгийн үндэслэл, цаашлаад боловсруулах шат хүртэл авч явах болно.

Манай нөөцийн тооцооны арга барил нь бүтцийн геологи, хүдрийн орд газрын геологи, геостатистикийн онолын ойлголт, нөөцийн тооцоо болон олборлолтын үйл ажиллагааны туршлага дээр тулгуурласан болно. Төсөл бүрийн нөөцийн тооцоо өөр өөр байдаг ч ерөнхийдөө дараах үйл ажиллагаатай байна.

- Бэлэн мэдээлэлд тоон болон чанарын үнэлгээ, мэдээллийн сангийн менежмент, баталгаажуулалт хийдэг
- Орд газрын 2 болон 3 хэмжээст геологи, эрдэсжилтийн загварчлал
- Мэдээллийн статистик, геостатистик шинжилгээ хийх, хамгийн тохиромжтой түвшин, нягтралын олон улсын арга барилыг тодорхойлох
- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн кодын дагуу ангилал, тайлан гаргах

Бидэнд геологийн загварчлал, геостатистикийн аргачлалын өргөн мэдлэг, туршлага бий. Вулкан программыг 1981 оноос хойш 38 жил хөгжүүлж боловсруулж байгаа билээ.

Бид бүхий л эрдэс баялаг, ордын төрөлд геологийн загварчлал, нөөцийн тооцоо боловсруулж үнэлэлт дүгнэлт хийж байсан туршлагатай. Мөн бид олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нөөцийн тайлагналтын код ашиглан ажиллахад мэргэшсэн, чадварлаг ажилчидтай.

Үйлчилгээ

- Орд газрын хайгуулын ажлын үнэлгээ
- Хайгуулын ажлын дээжлэлтийн үр дүн болон чанарын баталгаа, чанарын хяналтын үнэлэлт, дүгнэлт
- Нөөц тодорхойлоход өрөмдлөгийн байршлийг оновчтой болгох
- Хайгуулын ажил болон мэдээллийн сангийн менежмент
- Геологийн, бүтцийн, эрдэсжилтийн 2D, 3D загвар
- Геостатистик, геостатистикийн анализ
- ТЭЗҮ-гээс эхлээд үйл ажиллагаа явуулах хүртэлх төслийн бүхий л үе шатад нөөцийн тооцоо, ангилал, тайланг хийж гүйцэтгэх
- Геологийн судалгаа, нөөцийн тооцооны урьдчилсан эдийн засгийн үнэлгээ
- Борлуулж болохуйц металлын тооцоо, үйлдвэрлэлийн зохицуулалт

Илүү гүн – Илүү үнэ

цэнэ Арга барил

Маптек компанийн мэргэжилтнүүд уурхайн үйл ажиллагаа, техникийн арвин мэдлэг, туршлагатай бөгөөд дэлхийн олон улс орны уурхайд олон төрлийн эрдэс баялаг дээр олон төрлийн аргачлалаар ажиллан, туршлагажиж ирсэн билээ. Тиймээс манай шийдэл, зөвлөгөөнүүд зөвхөн практик, зохимжтой байгаад зогсохгүй зохих геотехник, гидрогеологи, эдийн засаг, байгаль орчны асуудлуудыг авч үзсэн байдаг.

Маптек үйлчилгээнд тойм судалгаа, урьдчилсан болон бүрэн хэмжээний техник эдийн засгийн үндэслэл, эдийн засгийн үнэлгээ, нарийвчилсан уурхайн загварчлал, үйлдвэрлэлийн хугацаа төлөвлөлт, тоног төхөөрөмжийн сонголт, үйл ажиллагааны зардлын тооцоо, капиталын зардлын тооцоо багтна. Манайд мөн уурхайн олборлох аргачлалд уламжлалт аргачлалаас ангид мэргэжлийн үнэлэлт дүгнэлт хийх мэргэжилтнүүд бий.

Evolution Startegy, Origin, Phase, Epoch програм хангамжууд дээрх загварчлал, сайжруулалт, оновчлол төлөвлөлт хийх үр чадвартай мэргэжилтнүүдтэй. Манай мэргэжилтнүүд Vulcan багц програм хамгамж дээр гүнзгий мэргэшсэн.

Бид эрдэс баялгийн нөөц, уурхайн бүх шатны ашиглалтын төлөвлөлт, техник эдийн засгийн модел бүхий нарийн тодорхой техникийн тайлан бэлтгэх уурхайн шинэлэг, бүтээлч, нарийн төлөвлөлтийн аргачлал хөгжүүлсэн. Энэхүү аргачлалын дагуу уурхайн оновчлолд хамгийн түрүүнд анхаарах бөгөөд ингэснээр стратеги төлөвлөлт, хэмнэлт, үр ашигтай олборлолт, үйл ажиллагааны хэмжээ, хүрээг тодорхойлно. Бид төслийн хувьд хамгийн сайн сонголтыг тодорхойлох, үйлчлүүлэгчид хандсан шийдлийг гаргахад зорьж ажилладаг.

Төслийг түргэн хугацаанд, төсөвт багтаан үйлдвэрлэлтэд шилжүүлэх хэрэгцээ улам нэмэгдэж байгаатай холбогдуулан, бид үйлчлүүлэгчийн өөрийнх нь техникийн нөөцийг ашиглан төслийг хүсч буй хугацаанд нь зорисон зорилгод нь хүргэх мэргэжилтнээр ханган уурхайн компаний үйл ажиллагааг хурдасгаж чадна. Манай ажилчид тухайн төслийг үнэлээд, төслийн хөгжлийг чиглүүлэхээр гаргасан шийдвэрүүд нь хамгийн боломжит богино хугацааг тодорхойлсон байхыг батлана.

Үйлчилгээ

- Тойм судалгаанаас эхлэн техник эдийн засгийн үндэслэл хүртлэх бүрэн хэмжээний судалгаа
- Уурхай урт, дунд, богино хугацааны төлөвлөлт, үнэлэлт дүгнэлт, техникийн аудит
- Оновчтой олборлолтын стратеги хөгжүүлэлт, хэрэгжүүлэлт
- Уурхайн үйл ажиллагааны тусламж, үнэлэлт дүгнэлт, сайжруулалт
- Санхүүгийн үнэлгээ
- Эрсдлийн шинжилгээ
- Төслийн үнэлэлт, дүгнэлт
- Эдийн засгийн урьдчилсан үнэлгээ
- Эрх бүхий мэргэжилтний тайлан
- Бие даасан мэргэжилтний тайлан
- Хөрөнгийн биржид бүртгүүлэхэд шаарлагатай тайлангууд



ОЮУ ТОЛГОЙ БОЛОН МАПТЕК КОМПАНИЙ АЖИЛТНУУД , ӨМНӨГОВЬ АЙМАГ ИХ БУЛАГ СУМ

Рио Тинто

Төсөл: Оюу толгой, Монгол.

Төслийн зорилго: Хүдрийн агуулгын хяналтын систем нийлүүлэх, нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээ

Үр дүн: Оюу толгойн ил уурхайн хүдэрийн агуулгын хяналтын програм хангамжийг Vulcan Grade control програм руу шилжүүлж, процесс хялбарчлах скриптүүдийг хэрэглэгчийн шаардлагад нийцүүлэн зохиож бусад уурхайн төлөвлөлт болон диспетчерийн программуудад шаардлагатай байгаа өгөгдлүүдийг бэлтгэн гаргаж өгсөн.

Шарын гол

Төсөл: Шарын гол, Монгол

Төслийн зорилго: Ил уурхайн оновчлол, богино хугацааны төлөвлөлтийн систем нийлүүлэх, нэвтрүүлэх

Үр дүн: Уурхай төлөвлөлтөд нүүрсний төрөл дэх боловсруулах ялгаатай зардлууд, уурхайн оновчлол. Төслийг сайжруулахад боловсруулах хүчин чадал, материал зохицуулах сонголт, байнгын болон ээлжийн сонголт, төслийн зохион байгуулалтын шинжилгээгээр дамжуулж ил уурхайн богино хугацааны төлөвлөлтийн програм нэвтрүүлэхэд голчлон анхаарсан.

Аспайр Майнинг

Төсөл: Овоотын нүүрс, Монгол

Төслийн зорилго: Овоотын нүүрсний ордын нөөцийн хэмжээст загварчлал, нөөцийн тооцоолол

Үр дүн: Овоотын нүүрсний ордын сав газарт нүүрсний илэрц бүхий DN335 цооног болон ZD001, ZD002 дугаарт өрөмдлөгийн цооногуудын хооронд 25 километр орчим талбай бий. Эдгээр цооногуудын мэдээлэл дээр үндэслэн геологийн 3 хэмжээст загварчлал, нөөцийн тооцоолол Вулкан програм хийж гүйцэтгэсэн.

Коделко

Төсөл: Сан-Хосе, Чили

Төслийн зорилго: Уурхайн оновчлол төлөвлөлт

Үр дүн: Уурхай төлөвлөлт оновчтой болгох судалгаагаар үйл ажиллагааны өөр өөр зардлууд, боловсруулалтын таамаглалын хэмжээг шалгаж, уурхайн боловсруулалтад илүү оновчтой хугацаа төлөвлөлт хийсэн.

Алдааг илрүүлж, хэрэгжүүлэхэд бэлэн болгоно

Арга барил

Төслийн үндсэн шийдвэрүүд, стратегийн талаар зохих шинжилгээ зөвлөгөө өгж, төслийн тань үнэ цэнийг баталгаажуулах нь бидний зорилго юм. Бид юу амжилтанд хүрэх, юу боломж авчирч, юу эрсдэл дагуулдгийг сайн мэднэ. Бид төслийн хамгийн чухал хэсгүүд дэх алдааг арилгахад анхааран ажилладаг.

Манай баг ажилчид зөвлөх үйл ажиллагаанд олон жил уул уурхайн ажилд оролцон, туршлага хуримтлуулсан. Энэхүү туршлага нь бидэнд геологи, нөөц, хаягдал, уурхайн төлөвлөлт оновчлол, уурхайг хаах зэрэг техникийн өргөн цар хүрээнд мэргэшин, туршлага хуримтлуулахад тусалсан юм. Энэ Нау-Хау, уурхайн нарийн технологи, инновацийн хэрэглээгээрээ бид олон улсын уул уурхай, банк, хөрөнгө оруулалтын байгууллагуудад хүлээн зөвшөөрөгдөж чадсан билээ.

Бид төсөл бүр дээр тухайн төслийн онцлогт тохирох багийг бүрдүүлж ажилладаг. Ихэнх тохиолдолд бид инженер, хангамж, барилгын менежментийн компаниудтай хамтарч, боловсруулалт, дэд бүтцийн тал дээр туслалцаа авдаг. Үүнтэй холбогдуулан бид инженер, хангамж, барилгын менежментийн хэд хэдэн компаниудтай нягт харилцаатай байдаг бөгөөд таны төсөлд тохирох компанитай түншлэн ажиллана. Маптек компаний үйлчилгээнд ил болон далд уурхайн төслийн тойм судалгаа, урьдчилсан болон бүрэн хэмжээний ТЭЗҮ багтдаг.

Бид танай төслийг геологи, геотехник, гидрогеологи, олборлолт, металлург, уурхайн хаалт, байгаль орчны, нийгмийн зэрэг бүхий л тулгамдсан сорилтыг давж гарахад туслах зөвлөгөөгөөр хангах болно.

Үйлчилгээ

- Тойм судалгаа, урьдчилсан болон бүрэн хэмжээний ТЭЗҮ
- Хууль ёсны өмчлөлийн судалгаа
- Олборлох аргачлалын шинжилгээ, сонголт
- Боловсруулах хүчин чадлын судалгаа
- Боловсруулалт, сайжруулалтын хугацаа төлөвлөлт
- Капитал, үйл ажиллагааны зардлын тооцоо
- Тоног төхөөрөмжийн сонголт
- Логистикийн хүчин чадлын судалгаа
- Инженер, дэд бүтцийн загварчлал
- Хүний нөөцийн тооцоо, менежментийн шаардлагууд
- Хэрэгжүүлэх хугацаа, төлөвлөлт
- Санхүүгийн шинжилгээний загварчлал, үнэлгээ